

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/36

Өлгий

**Эцэг, эхийн зөвлөл
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйл, Хүүхдийн хамгааллын тухай хуулийн 5, 6, 7, 8, 9, 10 дугаар зүйл, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого”, чиглэл батлах тухай 03 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын “Хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах” тухай 2018 оны 01 дүгээр албан даалгаврын 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд Хүүхэд хамгааллын чиглэлээр гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсролын ач холбогдлыг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхэд ээлтэй орчин бүрдүүлэх, хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Эцэг, эхийн зөвлөлийн дүрэм”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. “Эцэг, эхийн зөвлөлийн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөлийн дарга /И.Айнагүл/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/31 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Н.САКЕН



Зөвлөлийн дарга:

И.Айнагүл – НЭМТөвийн Нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан

Тэргүүлэгч:

Е.Сауле - НЭМТөвийн дарга, мэдээлэл сургалт сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Х.Арай- НЭМТөвийн Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
М.Амангүл – УТСХэлтсийн Архивын ажилтан
С.Еншигүл – УТСХэлтсийн нярав
А.Ерганат – ХШҮМХэлтсийн статистик мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
Т.Рахат – НЭМТөвийн хоол тэжээл хүнсний аюулгүй байдал хариуцсан ажилтан

Нарийн бичгийн дарга:

Х.Ахтилек – НЭМТөвийн Сүрьеэ, Бэлгийн замаар дамжих халдварын асуудал хариуцсан ажилтан